

УЛС ТӨР

Ч.СОДНОМЦЭРЭН: 57 ТОЙРГИЙН 80 ХЭСЭГТ НЭМЭЛТ САНАЛ ХУРААЛТ ЯВУУЛНА

II нүүрт

СПОРТ

Ц.БАТНАСАН:ТОКИО-2020 ЗУНЫ ОЛИМПЫН НААДМЫН ЭХНИЙ ЦИКЛЫД ЗАЛУУ ТАМИРЧДАА СОЙЖ БАЙНА

VIII нүүрт

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР



Өдөр +3

Шөнө -6

Дугаарын **60** мөр

Залуусын итгэл алдарчихаж

Н.ПУНЦАГБОЛД

Орон нутгийн сонгууль өнгөрсөн лхагва гаргач боллоо. Харамсалтай нь Улаанбаатар хотод ирц үнэхээр хангалтгүй байлаа. Одоо өч төчнөөн хэсэг дээр дахин санал хураалт явуулахаар болчихоод байж байна. Энэ бүхний гол буруутан нь залуучууд гэж хэлэх, ярих, бичих хүмүүс хаа сайгүй л байна.

Үргэлжлэл нь III нүүрт



Э.ТУУЛ

Монгол Улсын Ерөнхий сайд, УИХ-ын дарга нар өнгөрсөн долоо хоногт Япон, БНХАУ-д айлчилсан бол амралтын өдрүүдэд Орон нутгийн сонгууль болж өнгөрлөө. Тэгэхдээ



энэ удаагийн Орон нутгийн сонгуулийн ирц хүрээгүйгээс ирэх амралтын өдөр нэмэлт сонгууль явуулахаар боллоо. Мөн тун удахгүй болох гэж буй Засгийн газрын 100 хоногийн хүрээнд ямар ажлууд хийгдсэн талаар албаны хүмүүс мэдээлэл өгсөн



юм. Ингээд өнгөрсөн долоо хоногт болж өнгөрсөн үйл явдлууд болоод олон нийтийн цахим сүлжээнд ч асуудал үүсгээд амжсан "зоог", бусад асуудлаар хэн ямар байр суурь илэрхийлсэн талаар "Хэн юу хэлэв" булангаараа онцолж байна.

Д.Эрдэнэбат: Хяналтгүй явж буй МАН-ыг бид ард түмэнтэйгээ хамт заавал зогсоох ёстой

/УИХ-ын гишүүн/

Ардчилсан намын орон нутгийн сонгуулийн ерөнхий менежер, УИХ-ын гишүүн Д.Эрдэнэбат орон нутгийн сонгуулийн өмнө байр сууриа илэрхийлсэн юм. Тэрбээр "Энэ сонгуулиар Ардчилсан нам ард түмэнтэйгээ эрх баригчдын 100 хоногийг дүгнэлээ. Бид эрх

баригчдад мянган хоногт хийх ажлыг тулгаагүй, 100 хоногт Монголын нийгэм, улс төрийг хааш нь чиглүүлж байна вэ гэдэгт дун тавьж байгаа. Бага хугацаа биш ч, 100 хоногт улс орон, энэ ард түмэн хаашаа явах нь вэ гэдэг үндсэн чиглэлийг тогтооход хангалттай хугацаа. Харамсалтай нь, эрх баригчид сонгуулиар амласан бүх амлалтаасаа сонгогдсонхоо маргаашнаас шууд ухарч эхэлсэн. Бодлогын бүх шинэчлэл 100-хан хоногт арчигдаж, шилэн данс ширэн түрийвчний ард нуугдах жишээтэй.

Үргэлжлэл нь III нүүрт

Уншуулах тутам урамшуулал ИХ авна

ХААН Банкны КАРТАА
ХААН Банкны ПОС машин дээр

0.2%

2016.12.31 хүртэл

МЭДЭГДЭЛ

Энэ сарын 17-ны өдөр УИХ-ын гишүүн Ц.Нямдорж Эрдэнэт үйлдвэр ХХК Дарханы хар төмөрлөгийн үйлдвэр болон Хөтөлийн цемент шохойн үйлдвэртэй таван жилийн урт хугацааны гэрээ байгуулан, гэрээний урьдчилгаа төлбөрийн нийт дүн болох 100 гаруй тэрбум төгрөгийг гэрээнд гарын үсэг зурснаас ажлын тав хоногийн дотор "Эрдэнэт үйлдвэр"-ээс шилжүүлсэн хэмээн мэдэгдсэн.

Энэ асуудалд Эрдэнэт үйлдвэрээс албан ёсоор хариу тайлбар хийсэн байна. Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн Олон нийттэй харилцах албанаас гаргасан үг тайлбарт: "УИХ-ын 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 62 дугаар тогтоолоор батлагдсан "Төрөөс аж үйлдвэрийн талаар баримтлах бодлого"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.3-д "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр хийх худалдан авалтад дотоодын үйлдвэрийн бүтээгдэхүүнийг тэргүүн ээлжинд хамруулах тогтолцоог бий болгож, хэрэгжүүлэх" гэж заасны дагуу Эрдэнэт үйлдвэр ХХК нь улсын болон орон нутгийн аж ахуйн нэгж, үндэсний олон үйлдвэрүүдтэй хамтран ажиллах, дэмжих бодлого баримтлан ажилладаг.

Эрдэнэт үйлдвэр ХХК нь Дарханы хар төмөрлөгийн үйлдвэр, Хөтөлийн цемент шохойн үйлдвэртэй олон жилийн бизнесийн хамтын ажиллагаатай ажиллаж ирсэн бөгөөд энэхүү олон жилийн найдвартай хамтын ажиллагаа болон туршлагатай үйлдвэрлэгчээс чанартай түүхий эд нийлүүлэх, худалдан авах хэрэгцээ шаардлагад тулгуурлаж, бизнесийн уян хатан түншлэлийн хүрээнд энэ оны 8-р сарын 25-ны өдөр дээрх үйлдвэрүүдтэй 2017-2021 оныг хүртэл түүхий эд нийлүүлэх талаар хамтран ажиллах гэрээг байгуулсан болно.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 1011-д "Чанар, стандартын шаардлага хангасан барааг дотоодын үйлдвэрлэлээр хангах боломжтой тохиолдолд тендер шалгаруулалтад гадаадын бараа нийлүүлэгчийг шалгаруулахыг хориглоно" гэж, 101.2-д "Энэ хуулийн 1011-д заасан дотоодын үйлдвэрээс худалдан авах барааны жагсаалтыг Засгийн газар батална" гэж, мөн тус заалттай холбоотойгоор Засгийн газрын 2015 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн 336 дугаар тогтоолын 1 дүгээр заалтаар баталсан ДОТООДЫН ҮЙЛДВЭРЭЭС ХУДАЛДАН АВАХ ЧАНАР, СТАНДАРТЫН ШААРДАГАА ХАНГАСАН БАРААНЫ ЖАГСААЛТ-ын 8.3-д "Шохой", 9.1-д "Стандарт болон стандарт бус ган хийц"-ийг тус тус оруулсан байх тул Эрдэнэт үйлдвэр ХХК-ийн зүгээс үндэсний үйлдвэрлэгч байгууллагуудтай байгуулсан дээрх гэрээний хуулийн дагуу байгуулагдсан гэж үзэж байгаа болно.

Дээрх гэрээнд заасны дагуу бидний хамтын ажиллагаа хуулийн дагуу цаашид үргэлжлэх бөгөөд Эрдэнэт үйлдвэрийн зүгээс уг гэрээтэй холбоотой ямар нэг урьдчилгаа төлбөр өнөөдрийг хүртэл хийгдээгүй болохыг та бүхэнд үүгээр уламжилъя.

Иймд УИХ-ЫН ГИШҮҮН Ц.НЯМДОРЖИЙН МЭДЭЭЛЭЛД ДУРЬДСАНЧЛААН ДАРХАНЫ ХАР ТӨМӨРЛӨГИЙН БОЛОН ХӨТӨЛИЙН ЦЕМЕНТШОХОЙНҮЙЛДВЭРТ 100ГАРУЙ ТЭРБУМ ТӨГРӨГИЙН УРЬДЧИЛГАА ТӨЛБӨРИЙГ ШИЛЖҮҮЛСЭН ГЭХ МЭДЭЭЛЭЛ НЬ ОРҮНДЭСҮГҮЙ БОЛОХЫГ албан ёсоор мэдэгдэж байна.

ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР ХХК-ИЙН ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЛБА

ДЭЛХИЙ

ХИЛЛАРИ, ТРАМП НАР СҮҮЛЧИЙН ХАЛЗ МЭТГЭЛЦЭЭНЭЭ ХИЙЛЭЭ

Б.ДАВАА

АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн гурав дахь удаагийн халз мэтгэлцээн манай цагаар өчигдөр үдээс өмнө болж өндөрлөлөө. Ардчилсан намаас нэр дэвшигч Төрийн нарийн бичгийн дарга асан Хиллари Клинтон, Бүгд найрамдах намаас нэр дэвшигч үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп нарын сүүлчийн гэж хэлж болохуйц уг халз мэтгэлцээн Невада мужийн Лас Вегас хотноо болсон юм. Мэтгэлцээнд Хиллари цагаан өнгийн хослол өмссөн байсан бол Трамп хар өнгийн костюм өмсч, ялалтын өнгө гэгддэг улаан өнгийн

зангиагаар гоёсон байлаа. Мэтгэлцээний эхэнд, Х.Клинтон эмэгтэйчүүд болон бэлгийн цөөнхүүдийн эрхийг хамгаалахаа мэдэгдсэн бол Д.Трамп галт зэвсэг эзэмших эрхийг дэмжихээ мэдэгджээ. Санал асуулгын дүнгээс үзвэл, Д.Трамп бэлгийн дарамт үзүүлсэн гэх шүүмжлэлд өртсөнөөр гол гол муж улсуудад түүнийг дэмжигчдийн тоо цөөрсөөр байна. Түүний сацуу хатагтай Х.Клинтон ч мөн адил Америкийн сонгогчдын дунд нэр хүнд муутай байгаа бөгөөд түүнийг итгэл даах, найдвартай хүн эсэхэд сонгогчид эргэлзэж байгаа юм. Хоёр нэр дэвшигч улсын өр, эрүүл мэнд, нийгмийн халамж, цагаачлал, эдийн засаг гэх мэт зургаан сэдвийн

хүрээнд мэтгэлцсэн бөгөөд энэ үеэр хэд хэдэн анхаарал татсан үйл явдлууд болж өнгөрснийг тоймлон хүргэж байна.

Трамп сонгуулийн үр дүнг хүлээн зөвшөөрөхгүй хэмээв

Мэтгэлцээний үеэр ирэх сарын 8-нд болох Ерөнхийлөгчийн сонгуулийн санал хураалтад хэрэв Хиллари Клинтон ялбал, эцсийн дүнг хүлээн зөвшөөрөх үү гэх хөтөлгөөний асуултад үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан эр тун хачин хариу үйлдэл үзүүлжээ.

Үргэлжлэл нь IV нүүрт

МОНГОЛЫН МЭДЭЭ

18 дахь жилдээ

Манай сонины IV улирлын нэмэлт захиалга үргэлжилж байна

Улиралд **44** дугаар

Захиалгын үнэ 15400

Монгол шуудан: 70078977
УБ шуудан: 70127027
Скай пост: 70121294
Түгээмэл шуудан: 70115025

ХААН Банк				Худалгаа хөгжлийн банк				
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2319.00	2335.00	ФУНТ	2800.00	2902.00	АМ.ДОЛЛАР	2320.00	2335.00
ЕВРО	2514.00	2585.00	РУБЛЬ	35.80	39.00	ЕВРО	2514.00	2594.00
ИЕН	22.14	22.75	ЮАНЬ	343.30	347.20	ИЕН	22.09	22.85
						ФУНТ	2816.00	2905.00
						РУБЛЬ	36.08	39.45
						ЮАНЬ	343.50	347.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

СОНГУУЛЬ-2016

Ж.ОТГОН

Сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн дүнгийн талаар Сонгуулийн Ерөнхий хороо мэдээлэл хийлээ. СЕХ-ны дарга Ч.Содномцэрэн “Энэ удаагийн сонгуулиар 1765 тойргийн мэдээллийг хурдан хугацаанд нэгтгэх боломжгүй байсан. 15 мянган нэр дэвшигчийн мэдээллийг дэлгэц дээр гаргах техникийн боломжгүй байлаа. Сум, дүүргийн ИТХ-ыг зохион байгуулах дээд шатны байгууллага нь сум, дүүргийн сонгуулийн хороо байна гэж заасан байдаг. Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо мэргэжил, арга зүй талаас нь хангаж оролцох юм. Дүн мэдээг СЕХ нэгтгэхгүй, өргөн барихгүй. Харин хуульд зааснаар сум, дүүргийн сонгуулийн хороо дүн мэдээг тав хоногийн дотор багтаан гаргаж, сум дүүргийн Иргэдийн хуралд өргөн мэдүүлнэ. Нийтэд долоо хоногийн хугацаанд мэдүүлэх юм. Санал хураалтын ажиллагаа дуусаагүй. Зарим хэсгүүд дээр ирц хүрээгүй учраас энэ сарын 23-ны ням гарагт нэмэлт санал хураалт явуулна. Нэмэлт санал хураалтад саналаа өгөөгүй иргэд оролцоно. Санал өгсөн хүн дахин санал өгөхгүй” гэлээ. Тухайлбал, 1765 тойргийн 135 тойрог дээр нэмэлт санал хураалт явагдана. Аймагт 57 тойрогт, нийслэлд 78 тойрогт нэмэлт санал хураалт явуулна. Ингэж байж сонгуулийн нэгдсэн дүн гарна гэлээ. Үүнээс 2082 хэсгийн 293 хэсэг дээр нэмэлт санал хураалт явуулна. Аймгуудад 80 хэсгийн хороон дээр, нийслэлд 213 хэсэгт нэмэлт санал хураалт явуулах юм байна. Мөн нэр дэвшигчдийн санал тэнцсэн тохиолдол цөөнгүй гарчээ. Хуулиараа дахин санал хураалт явуулах юм байна. Нийтдээ 19 аймгийн 117 нэр дэвшигчийн санал тэнцсэн байна. Дахин санал хураалтыг аравдугаар сарын 29-ний өдөр



Ч.СОДНОМЦЭРЭН: 57 ТОЙРГИЙН 80 ХЭСЭГТ НЭМЭЛТ САНАЛ ХУРААЛТ ЯВУУЛНА

зохион байгуулах аж. Нэмэлт санал хураалт, дахин санал хураалт нь хоёр өөр ажиллагаа гэдгийг тэрбээр онцлон хэлсэн юм. Тухайлбал ямар, ямар газруудад нэмэлт санал хураалт явуулах талаар СЕХ-ны нарийн бичгийн дарга Болдсайхан мэдээлэл өглөө.

-Архангай хоёр тойрог, хоёр хэсэг
-Баянхонгор хоёр тойрог, хоёр хэсэг

-Говь-Алтай нэг тойрог, нэг хэсэг
-Дорнод зургаан тойрог, найман хэсэг
-Дундговь нэг тойрог, нэг хэсэг
-Өмнөговь гурван тойрог, гурван хэсэг
-Хөвсгөл есөн тойрог, есөн хэсэг
-Хэнтий нэг тойрог, нэг хэсэг
-Дархан-Уул 15 тойрог 23 хэсэг

-Орхон 17 тойрог, 27 хэсэг
ДҮҮРГҮҮД:
-Багануур нэг тойрог, хоёр хэсэг
-Баянгол есөн тойрог, 17 хэсэг
-Баянзүрх 24 тойрог, 71 хэсэг
-Сонгинохайрхан 21 тойрог 61 хэсэг
-Сүхбаатар таван тойрог, есөн хэсэг
-Хан-Уул таван тойрог 14

хэсэг
-Чингэлтэй 15 тойрог, 39 хэсэгт нэмэлт санал хураалт явуулах юм байна. Дахин санал хураалт болон нэмэлт санал хураалт дээр босго гэж байхгүй юм.

Нийслэлчүүдийн 48.8 хувь нь саналаа өглөө
21 аймгийн 57 тойргийн 80

хэсэгт нэмэлт санал хураалт явуулах бол нийслэлийн хувьд долоон дүүргийн 78 тойргийн 283 хэсэгт нэмэлт санал хураалт явуулахаар болжээ. Нийслэлд 295 мандатын төлөө 152 тойрог байгуулагданажилласан. Үүнээс дараах хороодод ирц хүрээгүй.

-Сүхбаатар дүүрэг 35 мандат 20 тойрогтой. Үүнээс 15 тойрогт ирц бүрдсэн. Харин үлдсэн тавд хүрээгүй нь буюу Сүхбаатар дүүргийн 1,3,9,10,11 дүгээр хорооны есөн санал авах байрны ирц хүрээгүй.

-Хан-Уул дүүрэг 16 хороотой 11 хороонд ирц хүрсэн. Тус дүүргийн 2,3,4,11,15 дугаар хорооны 14 санал авах байрт ирц хүрээгүй.

-Баянгол дүүрэг 23 хороотой. 15 хороонд ирц бүрдсэн. 1, 3,4,5,6,7,10,20 дугаар хорооны /нийт нийаман хороо/ 17 санал авах байранд нэмэлт санал хураалт явагдана.

-Баянзүрх дүүрэг 28 хороотой. Дөрвөн нь хороонд ирц бүрдсэн. 24 хороонд ирц хүрээгүй. Тодруулбал БЗД-ийн 2-5, 7-12, 16-22 дугаар хорооны 71 санал авах байранд нэмэлт санал хураалт явагдах юм байна.

-Чингэлтэй 19 хороотой. Дөрвөн хороонд ирц хүрсэн. Тус дүүргийн 4,5,7-19 дүгээр хорооны 39 санал авах байранд ирц хүрээгүй.

Сонгинохайрхан дүүрэг 32 хороотой. 11 хороонд ирц бүрдсэн. 21 хорооны 61 санал авах байранд ирц бүрдээгүй. Тодруулбал, 1-5, 7,9,11,13,17-19, 21-26, 28, 29, 31 дүгээр хороонд ирц бүрдээгүй.

-Багануур дүүрэг таван хороотойгоос нэгд нь ирц хүрээгүй. Тиймээс 5 дугаар хорооны хоёр санал авах байранд нэмэлт санал хураана. Тиймээс нийт 213 санал авах байранд нээлт санал хураалт явагдана. Харин Налайх, Багахангай дүүрэгт ирц бүрдсэн тул нэмэлт санал хураалт явуулахгүй юм байна.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

ЗАСГИЙН ГАЗРЫН 100 ХОНОГИЙН ХУГАЦААНД НИЙТ 39.1 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫГ АШИГЛАЛТАД ОРУУЛЖЭЭ

Н.ЗАЯА

Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат салбарынхаа төлөөлүүдтэй уулзаж, харилцан санал солилцож, тулгамдаж буй асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх талаар зөвлөлдөж байгаа. Энэ удаад авто замынхантай уулзлаа. Уулзалтын эхэнд сайд Д.Ганбат авто замын сүлжээг өргөжүүлэн хөгжүүлэх хэрэгцээ, шаардлага улам бүр өсөн нэмэгдэж, авто замын салбарт нэлээдгүй хөрөнгө оруулалт хийгдсэн талаар онцоллоо. Тус яамнаас орон нутагт зорчих нийт иргэдийн ая тухтай байдлыг хангах үүднээс 2016 онд авто замын салбарт улсын төсөв, гадаадын зээл тусламж, концессын хөрөнгө оруулалтаар томоохон төслүүдийг хэрэгжүүлэхээр ажиллаж эхэлжээ. Авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замын урт 2015 оны байдлаар 44.7 хувьд хүрсэн бөгөөд өнөөдрийн байдлаар Төв, Архангай, Өвөрхангай, Булган, Хөвсгөл, Орхон, Сэлэнгэ, Дархан-уул, Говьсүмбэр, Хэнтий, Сүхбаатар, Дорноговь, Дундговь, Өмнөговь, Баянхонгор зэрэг 15 аймаг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбогдсон байгаа. Цаашид энэ ажлыг эрчимтэй үргэлжлүүлэхээр төлөвлөн ажиллаж байгаа юм байна.

Засгийн газрын 100 хоногийн хугацаанд авто замын салбарын бүтээн байгуулалтын ажлын хүрээнд Сэлэнгэ аймгийн Ерөө сумын Ерөө гол дээрх 272.7 у/м төмөр бетон гүүр, Улаанбаатар хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлыг Өндөрдовын жуулчны баазтай холбох 3.8 км, Улаанбаатар-Мандалговь чиглэлийн автозамыг Өндөрдовын жуулчны баазтай холбох 5.1 км, Налайх-Тэрэлж чиглэлийн 30.2 км нийт 39.1 км хатуу хучилттай авто замыг ашиглалтад оруулсан байна. Мөн Халзанбүргэдэй-Солонготын даваа чиглэлийн 100 км авто замын үлдэгдэл 58 км, Цахир-Тосонцэнгэл чиглэлийн 127.1 км авто замаас 120 км, Өндөрхаан-Чойбалсан чиглэлийн 143 км хатуу хучилттай авто замаас 77.8 км-ыг тус тус хэсэгчлэн ашиглалтад оруулсан аж. Түүнчлэн Элсэнтасархай-Хархорины Орхоны гүүр чиглэлийн 77 км, Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 9.8 км нийт 342.6 км хатуу хучилттай авто зам болон Хэнтий аймгийн Баянмөнх сумын Хэрлэн голын 217.2 у/м төмөр бетон гүүрийг тус тус ашиглалтад оруулахаар бэлтгэл ажлыг хангасан талаар сайд танилцуулгадаа дурьдлаа. БНХАУ-ын Засгийн газрын экспортын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр Завхан аймгийн төвийг нийслэлтэй холбох замын хэсэг болох Тосонцэнгэл-Улиастай чиглэлийн 114 км, Говь-Алтай аймгийн төвийг нийслэлтэй холбох замын хэсэг болох Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129.4 км хатуу хучилттай авто замын барилгын бэлтгэл ажлыг хангаж, зам барилгын бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлжээ.

Улаанбаатар-Хөшигийн хөндийн олон улсын шинэ нисэх онгоцны буудал чиглэлийн 32.2 км хурдны замын 0-22.5 дахь км-т авто замын барилгын ажил үргэлжилж байгаа аж. Ургац тээвэрлэх Шаамар сум-Зүүнбүрэн сум-Цагааннуур сум-Түшиг сум чиглэлийн 109 км хайрган хучилттай авто зам, Ерөө сум-Шандын даваа-Хазайн



бригад хүртэлх 40 км хөрсөн зам, Хүдэр сумаас Ерөө сум хүртэлх 50 км сайжруулсан болон хайрган хучилттай авто зам болон Хазайн голын 7 у/м модон гүүрийн засвар арчлалтад шаардлагатай 274.8 сая төгрөгийг 2016 оны улсын төсөвт тусгуулж, засварын ажлыг хийж дуусгасан байна. Автозамын бүтээн байгуулалтад шинэ технологи нэвтрүүлэх ажлын хүрээнд БНСУ-ын Барилгын технологийн институттай хамтран “Монгол Улсын зам барилгын үйлдвэрлэлд сайжруулсан бүлээн асфальт хольцыг нэвтрүүлэх, нутагшуулах”, “Шилэн мяндсаар хүчигтгэсэн асфальт-бетон технологийг нэвтрүүлэх, нутагшуулах”, ОХУ-ын Техникийн их сургуультай хамтран “Бүлээн асфальтбетон хучилтыг нэвтрүүлэх, нутагшуулах ажлын хүрээнд полимерболон эрдэснэмэлтийн лабораторийн туршилт”, “Авто зам, гүүрийн барилга, засварын машин механизмын машин цагийн жишиг үнэ тооцох дүрмийг боловсруулах, машин цагийн тарифыг шинэчлэн боловсруулах” норм, судалгааны ажлуудыг тус тус

хэрэгжүүлж байна. Цаашид автозамын салбарт “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр” “Монгол Улсын эдийн засаг нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн хүрээнд дараах зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Үүнд: Олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын сүлжээг өргөтгөж, бүх аймгийн төвийг нийслэлхоттой авто замаар холбож дуусгах, Мянганы замын хэвтээ тэнхлэгийн авто замын захыг үргэлжлүүлэхээр төлөвлөжээ. Мөн Улаанбаатар хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан авто замын сүлжээг сайжруулах зорилгоор Баянзүрх, Яармаг, Сонгсололгийн гүүр болон Улаанбаатар-Налайх чиглэлийн автозамыг шинээр барих гэнэ. Түүнчлэн Авто замын засвар арчлалтын хугацааг уртасгах, чанарыг сайжруулах, хөрөнгийн эх үүсвэрийг үе шаттай нэмэгдүүлэх юм байна. Дээрх зорилтын хүрээнд авто замын салбарт ирэх дөрвөн жилд Олон улсын авто замын сүлжээ буюу Азийн авто

замын сүлжээний АН4 (баруун босоо тэнхлэгийн авто зам болох Ярант-Улаанбайшинт) чиглэлийн авто замыг бүрэн ашиглалтад оруулах, үлдэж буй зургаан аймаг болох Дорнод, Говь-Алтай, Ховд, Завхан, Увс, Баян-Өлгий аймгийг нийслэл хоттой хатуу хучилттай авто замаар холбож дуусгах, хилийн боомтуудыг аймгийн төвүүдтэй холбох ажлыг эхлүүлж, орон нутгийн хөгжил болон тухайн бүс нутгийн иргэдийн амьжиргааг дээшлүүлэхэд чиглэгдсэн орон нутгийн чанартай авто замыг үе шаттайгаар барьж байгуулах, нийслэл хотын авто замын сүлжээг өргөтгөн хөгжүүлэх, хотын баруунаас зүүн, хойноос урд чиглэлд хурдны зам барих, гүүрэн гарц, дугуйн зам барих зэрэг арга хэмжээг тус тус хэрэгжүүлэхээр ирэх дөрвөн жилд хийх ажлын төлөвлөгөөндөө тусгажээ. Уулзалтын үеэр авто замчид олон чухал санал санаачлага хэлж байсан бөгөөд хамгийн гол нь эрх зүйн орчныг боловсруулах болгох шаардлагатай гэдгийг хэлж байсан юм.

ММINFO
МОНГОЛЫН МЭДЭЭ
18 дахь жилдээ

Ерөнхий эрхлэгч: **С.ГАНТОГОО**

Орлогч эрхлэгч: **Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ**
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: **Э.ЭНХЦЭЦЭГ**
88873012

Ахлах редактор: **Б.ӨНӨРТОГТОХ**
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: **Н.ПУНЦАГБОЛД**
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: **Б.ӨНӨРТОГТОХ**
88006842

Гэрэл зургийн алба: **Г.АРГУУЖИН**
96017873

Компьютерийн алба: **Б.ГАНЗОРИГ**
99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: **Н.АЛТАНЦЭЦЭГ**
99173710

Захиалга, борлуулалтын алба: **М.ДАВААДУЛАМ**
99042510

Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхлэсэн **Э.ЭНХЦЭЦЭГ**

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: **Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот**

Харилцах утас, факс: **976-70113551**

“Монголын мэдээ” сонины редакцт эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ДЭЛХИЙ

Үргэлжлэл.
Түүрч нь I нүүрт

Нэг үгээр хэлбэл, асуултад хариулахаас татгалзсан гэнэ. Тэрбээр “Тэр үед нь болно” гэх ганц үгээр хариулахаас зайлсхийжээ. Доналд Трампын хувьд хэвлэл мэдээллийн байгууллагууд хэт нэг талд үйлчилж буйг шүүмжилсэн байна. Тэрбээр “Хэвлэл мэдээллийн хэрэгслүүд хэт нэг талыг барьж ажиллаж байна. Хиллари Клинтон “Клинтон санд гэхэд the Wall Street эрэг томоохон мэдээллийн магнатууд хандив өргөдөг. Мэтгэлцээн ч гэсэн түүний талд явагддаг. Мэдээллийн хэрэгслүүд шударга бус байна. Хиллари Клинтон цажим шуудангийн асуудлыг яагаад өнөөг хүртэл Холбооны мөрдөх товчоо шалгахгүй байгаа юм? Яагаад ямар ч мэдээллийн хэрэгсэл асуудал болгон гаргаж ирж, ярихгүй байгаа юм” хэмээсэн. Тэрбээр өмнөх халз мэтгэлцээнээр хэрэв Ерөнхийлөгчөөр сонгогдвол Хиллари Клинтон шалгах тусгай баг томилж, түүнийг шоронд оруулах хүртэл арга хэмжээ авна гэдгээ мэдэгдсэн. Харин Хиллари Клинтон “Доналд Трамп үйл явдлууд өөрийнх нь хүслээр явагдахгүй болоод ирэхээр иймэрхүү зүйлс ярьж байна. Миний цажим шуудангийн асуудал хэдийнэ шийдэгдсэн. Тагнуулын тов газраас шалгаад асуудалгүй болохыг нь тогтоосон шүү дээ. Трамп Тагнуулын төв газарт ч, Шүүхийн шийдвэрт ч итгэхгүй байгаа. Заавал таны хүссэнээр бүх зүйл өрнөх боломжгүй гэдгийг сана” гэсэн байна. Түүнчлэн, Трамп “нэг сая” орчим “царцаа” бүртгэгдсэн гэдгийг онцолж байсан юм. Харин Хиллари үүнийг нь 240 жилийн түүхт АНУ-ын Ардчиллыг гутаасан явдал гэж үзэж буйгаа илэрхийлээд, Доналд Трампыг АНУ-ын орчин үеийн түүхэн дэх хамгийн аюултай нэр дэвшигч гэж тодорхойллоо.

Хиллари үр
хөндөлтийг
дэмжжээ

Гурав дахь удаагийн

ХИЛЛАРИ, ТРАМП НАР СҮҮЛЧИЙН ХАЛЗ МЭТГЭЛЦЭЭНЭЭ ХИЙЛЭЭ

мэтгэлцээнийг “Фокс ньюс”-ын Крис Уоллес хөтлөн явуулсан бөгөөд тэрбээр хаягдсан гэж хэлж болохуйц нэгэн сэдвийг хөндөн нэр дэвшигчдээр хэлэлцүүлсэн нь олны анхаарлыг татаж байв. Түүний хувьд шүүх засаглалын талаархи тэдний бодлыг сонирхсон. Энэ асуултад Клинтон ямар улс болохыг зорьж байгаа нь л Ерөнхийлөгчийн сонгуулийн гол анхаарах ёстой асуудал гэдгийг онцолж, ижил хүйстэн, эмэгтэйчүүдийн тэгш эрхийн асуудалд анхаарал хандуулахыг уриалсан байна. Нөгөөтэйгүүр, Доналд Трамп улсын дээд шүүхэд үр хөндөлтийг эсэргүүцэж, иргэдийг буу эзэмших эрхийг хангаж ажиллах чадвартай хүнийг томилгоо амлаад авчээ. Хөтлөгч нэр дэвшигчдээс үр

хөндөлтийн тухай ямар байр суурьтай байгааг нь асуухад, Хиллари Клинтон “Үндсэн хуулиар олгогдсон эрхийн дагуу эмэгтэйчүүд нөхөн үржихүйн тухай өөрөө бие даан шийдвэр гаргах эрхтэй. Эхийн эрүүл мэнд, амь насанд аюултай болон бусад зайлшгүй тохиолдолд үр хөндөлт хийхээс аргагүй үе цөөнгүй тохиолддог. Тиймээс энэ эрхийг эмэгтэйчүүдэд өөрсдөд нь үлдээх хэрэгтэй” гэсэн бол Доналд Трамп “Есөн сар болсон жирэмслэлтийг таслан зогсооно гэдэг аймшигтай хэрэг. Би хэрхэвч үүнийг дэмжиж чадахгүй. Хилларигийн хэлж буйгаар төрөх гэж буй ургийн эхийн хэвлийгээс нь хүчээр авах болох нь” хэмээн байр сууриа илэрхийлэв. Харин Клинтон “Ийм аймшигтай жишээ татаж

...Хэдийгээр мэтгэлцээний дараа нэр дэвшигчдийн аль нь ялсныг шууд тогтоох боломжгүй ч, Си Эн Эн агентлагийн халз мэтгэлцээний дараа явуулсан олон нийтийн санал асуулгад Ардчилсан намаас нэр дэвшигч Хиллари Клинтон илт давуугаар ялсан үзүүлэлт гарчээ...

байгаа нь тун эмгэнэлтэй” хэмээж мэд тавилаа.

Трампыг В.Путины утсан хүүхэлдэй болно гэв

Хиллари Клинтон оросуудад талтай биш гэдгээ харуулсаар байна. Ялангуяа Ерөнхийлөгчийн сонгууль болоход сар хүрэхгүй хугацаа үлдсэн энэ үед ОХУ-ын хакерчид АНУ-ын мэдээллийн технологид халдаж, кибер халдлага үйлдэж байгаа тухай

тэрбээр удаа дараа, халз мэтгэлцээн бүрт ярьж байгаа юм. Хиллари Оросууд Доналд Трампд туслахаар, түүнийг сонгууль ялуулахаар кибер халдлага үйлдэж байгаа тухай өнөөдрийн халз мэтгэлцээнд дахин хэллээ. Түүнчлэн, Доналд Трамп АНУ-ын Ерөнхийлөгч болсон тохиолдолд В.Путины “Утсан хүүхэлдэй” болно гэдгийг сайтар тунгаан бодохыг сануулсан байна. Харин Трамп түүнд “Улс орны эрх ашиг, аюулгүй байдалд мэдээллийн технологи, кибер аюулгүй байдал чухал болох тухайд тангтай санал нэг байна. Гэхдээ Кибер халдлагыг оросууд, хятадууд хэн нь үйлдэж байгааг та бид хэн нь ч тогтоогоогүй үед ингэж өөрийн хувийн үзлээр ярих нь тохиромжгүй юм” хэмээн сануулав. Түүнчлэн, Доналд Трамп өөрийгөө ОХУ-ын Ерөнхийлөгч В.Путинтай ойр харилцаатай гэх мэдээллийг үгүйсгэж, Хиллари Клинтон хэд дахин илүү чадвартай Ерөнхийлөгчтэй сайн харилцаатай ажиллана гэдгээ хэлжээ.

Хиллариг “бузар хүүхэн” гэжээ

Нэр дэвшигчдийн мэтгэлцээн дүрвэгсдийн асуудлаас Сирийн иргэний дайн хүртэлх өргөн сэдвийн хүрээнд өрнөсөн байх бөгөөд мэтгэлцээн ширүүсэх бүрт нэр дэвшигчдийн хувийн зан араншин ил гарч байсныг томоохон мэдээллийн агентлагууд онцолж байна. Тэдгээрээс хамгийн их анхаарал татсан нь Хиллариг микрофоноо барин өөрийн үзэл бодлоо илэрхийлж байх үед биеэ барьж дийлээгүй Трамп “Бузар хүүхэн” хэмээн хараасан гэнэ.

Дүрвэгсдийн асуудлаас үүдэлтэйгээр тэд нэлээд ширүүн маргалджээ. Улмаар Хиллари Доналд Трампын хууль бус цагаачдыг албадан нутаг буцаана гэх амлалтыг шүүмжилж, “Манай улсыг хоёр хуваах нь” гэх хоржоонтой үгийг хэрэглээд амжсан байна. Харин үүний дараа хөтлөгч Хиллари Клинтон “Хэрэв Ерөнхийлөгч болбол улсын өр болон баячуудын татварын асуудлыг хэрхэн шийдэх талаархи асуудлыг асуусан аж. Улмаар үүнд хариулж байхад нь Трамп “Бузар хүүхэн” хэмээн Хиллариг хараагаад авчээ. Ямартай ч, энэ мэт ширүүн уур амьсгалтай өрнөсөн гурав дахь удаагийн халз мэтгэлцээний дараа нэр дэвшигчид харилцан гар барилгүй салсан байна.

Мэтгэлцээн
Хиллари
Клинтон
ялалтаар
өндөрлөлөө

Хэдийгээр мэтгэлцээний дараа нэр дэвшигчдийн аль нь ялсныг шууд тогтоох боломжгүй ч, Си Эн Эн агентлагийн халз мэтгэлцээний дараа явуулсан олон нийтийн санал асуулгад Ардчилсан намаас нэр дэвшигч Хиллари Клинтон илт давуугаар ялсан үзүүлэлт гарчээ. Тодруулбал, санал асуулгад оролцогсдын 52 хувь нь Хиллари Клинтонг дэмжиж буйгаа илэрхийлсэн бол 39 хувь нь Доналд Трампыг мэтгэлцээнд ялсан гэж үзсэн байна. Гурав удаагийн мэтгэлцээний төгсгөлд зарим хэвлэл мэдээлэл Хиллариг ирэх сарын 8-нд болох Ерөнхийлөгчийн сонгуульд ялах нь нэгэнт тодорхой болсон хэмээн дүгнэж байгаа юм.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

Дэлхийн хамгийн том аквариумыг ирэх сард нээнэ

Дэлхийн хамгийн том далайн амьтны музей Бразилд тун удахгүй нээлтээ хийх гэж байна. “АгуаРио Аквагиум” гэх далайн амьтны музей ирэх сарын 9-нд Бразилын Рио де Жанейро хотноо нээлтээ хийх аж. Музейг байгуулахын тулд тус хотын захиргаа 40.6 сая ам.долларыг зарцуулсан байх бөгөөд аквариумд 4.5 сая литр далайн усыг хийсэн байна. Түүнчлэн, 350 төрлийн 3000 гаруй зүйлийн далайн амьтдыг тус музейд байршуулахаар төлөвлөжээ. Ингэхдээ тус амьтдын 90 хувь нь зөвхөн тус улсад байдаг амьтад байх ёстой гэнэ.

“Лалын улс”-ын толгойлогчид зугтаж эхэлжээ

Иракийн арми Мосул хотод дөхөн ирж байгаатай холбоотойгоор “Лалын улс” бүлэглэлийн толгойлогчид тус хотоос зугтан гарсаар байна гэж АНУ-ын цэргийнхэн мэдэгдэв. Иракийн цэргүүд улам хүчтэй довтолж байна гэж генерал Гэри Волески мэдэгдлээ. Иракийн арми Мосул хотын өмнөд талаас давшиж байгаа бол Курдын хүчин зүүн талаас нь довтолж байгаа юм. Одоогийн байдлаар тус хотод “Лалын улс” бүлэглэлийн 5000 орчим гишүүд байгаа хэмээн албаныхан тооцжээ. “Бид Мосулаас гарч буй шилжилт хөдөлгөөнийг илрүүлсэн, тус бүлэглэлийн толгойлогчид хотыг орхин гарсан гэж бид үзэж байна” хэмээн генерал Гэри Волески мэдэгдсэн байна. Гэхдээ тэрбээр яг хэн, хаашаа зугатан гарсан талаар дэлгэрэнгүй мэдээлэл өгөөгүй аж. Түүнчлэн, “Лалын улс” бүлэглэлийн толгойлогч Абу Бакр аль-Багдади хаана байгаа нь тодорхойгүй байна. Зарим мэдээлэлд түүнийг Мосул хотод байгаа гэсэн бол хотоос гарч явсан гэх мэдээлэл ч мөн иржээ.



ROYAL IRISH PUB
7 ЖИЛИЙН ОЙН БАЯР



ROYAL GRILL RESTAURANT



ROYAL BEER FESTIVAL 2016
10.20-10.28 дуустал

Урилгаар
- Koln хамтлаг
- Гитар уйлуулагч Гантулга
- RecOp хамтлаг
- Madness хамтлаг
- Дуучин БоБо хамтлагтайгаа болон бусад хамтлаг дуучид, олон төрлийн сюрприз, сонирхолтой уралдаан тэмцээнүүд үдэш бүр таныг хүлээж байна.

Шинэ ургацын шар айраг
Хамтлаг дуучдын тоглолт
Сонирхолтой олон
уралдаан тэмцээнүүд

Шинэ рестораны нээлтийн хямдралд БҮХ ХООЛ 7000₮ болон хямдарлаа.

ЗАХИАЛГА АВАХУТАС 9903-4188











Хаяг: БЗД, 13-р хороолол, зүүн дөрвөн зам уруудаад Royal House зочид буудлын 1 давхарт ROYAL IRISH PUB

3-р хороолол Өргөө Номингийн хойморьт Роял хоус Зочид буудлын 2 давхарт ROYAL GRILL RESTAURANT



СПОРТ



“ЛЕСТЕР”-ИЙН “ҮНСГЭЛЖИНГИЙН ҮЛГЭР”
ҮРГЭЛЖИЛЖ, “БАРСЕЛОНА”-ГИЙНХАН
ПЕПИЙГ ГОМДООЛОО

ДЕРРИК РӨҮЗД ХАМГААГАХ БОГДОХ ХЭРГИЙГ
ХЭРЭГСЭХТЭЙ БОЛГОЖЭЭ

VI нөср

Кэвин Дурант.

ОДДЫН ЦАГ

МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ

Чөлөөтийнхөн их хурлаа ирэх сард товложээ

Монголын спорт холбоодууд “РИО-2016” олимпын наадмаас хойш өнгөрсөн 90 хоногт багтаж, дөрвөн жилийн тайлангаа хэлэлцэн, дараагийн олимпын наадамд бэлтгэх үндсэн зорилгоо тодорхойлох хурлаа зохион байгуулдаг уламжлалтай. Олон улсын спортын холбоод ч энэ жишгийг барьж ажилладаг. Монголын спортын холбоодоос “Рио-2016” олимпын наадмын дараа одоогоор Жүдо бөхийн холбоо есдүгээр сарын 14-нд Их хурлаа хийж, холбооны удирдлагуудаа сонгож, дотоод асуудлаа ярилцаад байгаа.

Харин өнгөрсөн дөрвөн жил үл ойлголцож, холбоо дотроо маргаан дагуулж ирсэн Монголын чөлөөт бөхийн холбоо 11 дүгээр сарын 19-нд хуралаа хийхээр товлоод байгаа аж. МЧБХ-ны Их хурлаар холбооны ерөнхийлөгчийн ээлжит сонгууль явуулж, ерөнхийлөгч, Хөдөлмөрийн баатар Д.Дагвадоржид итгэл хүлээлгэх эсэхээ шийдэх юм.

Сагсчид Э.Содномпилжээд “Жордан” бэлэглэжээ



Бразилын Рио де Жанейро хотод зохион байгуулагдсан паралимпийн 15 дахь удаагийн наадамд эх орноо төлөөлөн оролцож бахархам амжилт гаргасан Э.Содномпилжээд Монголын Үндэсний сагсан бөмбөгийн холбооноос алтан шаргал өнгөтэй Жордан брэндийн пүүз бэлэглэжээ. Пауэрлифтингийн спортын тамирчин, ШШГЕГ-ын “Сүлд” спорт хорооны тамирчин Э.Содномпилжээ оролцсон төрөлдөө анх удаагаа паралимпод Монгол Улсаа төлөөлж, мөнгөн медалийн энтэй хүрэл медаль хүртсэн юм. Улмаар түүний амжилтыг сагсчид ийнхүү үнэлж, сэтгэлийн бэлгээ гардуулсан нь энэ. Түүнчлэн, сагсан бөмбөгийн тоглолтыг үзэх хүндэт зочноор урьжээ.



Монголын туялзуур сэлэмний холбоо, МХБХ-той хамтарна

Монголын хөлбөмбөгийн холбоо, Монголын туялзуур сэлэмний холбоодын менежментийн үр ашгийг нэмэгдүүлэх, маркетинг, хүний нөөц, техник, дэд бүтцийг хөгжүүлэхэд хамтран ажиллах, тулгарч буй саад бэрхшээлийг арилгах зорилгоор 2020 он хүртэлх хамтын ажиллагааны санамж бичигт гарын үсэг зурлаа. Гарын үсэг зурах ёслол Монголын хөлбөмбөгийн холбооны байранд боллоо. Хоёр тал дараах чиглэлүүдээр хамтран ажиллана. Холбооны ажлын албаны хүний нөөцийн үр чадварыг нэмэгдүүлэх, холбооны засаглал, бүтэц, дүрэм, зохион байгуулалтыг сайжруулах чиглэлээр санал солилцох, холбооны маркетинг, хөрөнгө босгох чиглэлээр санал солилцоно. Мөн хамтарсан үйл ажиллагаа явуулах, хоёр холбооны дэд бүтцийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх, спортын мэдээллийн баазыг хамтран хөгжүүлж, боловсруулж ажиллах юм. Санамж бичигт гарын үсэг зурах ёслолд МХБХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга Ө.Шижир, МТСХ-ны ерөнхий нарийн бичгийн дарга Б.Хосбаяр болон бусад албаны хүмүүс оролцлоо.



БИ БҮГДЭД ТААЛАГДАХ АЛБАГҮЙ

Дэлгэрэнгүй ярилцлагыг VII нүүрнээс

Сүмо бөхчүүд сүүлийн башёгийн бэлтгэлдээ гарлаа

Японы мэргэжлийн сүмо бөхийн ирэх сарын тэмцээний өмнөх үзүүлэх тоглолтууд үргэлжилж байгаа бөгөөд бөхчүүд 2016 оны сүүлийн башёгийн бэлтгэлдээ ийнхүү базааж эхэлжээ. Энэ жилийн зургаан башёгийн хоёрт нь Японы сумоч түүрүүлсэн. Тухайлбал нэгдүгээр сарын башёд озэки Котшёогнику түүрүүлсэн бол есдүгээр сарын башёд Гөйдё тэргүүлж, Японы эзэн хааны цом хүртсэн. Гөйдёгийн хувьд өнгөрсөн сарын башёд нэг ч унаагүй түүрүүлсэн нь япон бөх 20 жилийн дараа уналгүй түүрүүлсэн амжилт болсон гэдгээрээ онцлогтой. 2016 оны гуравдугаар болон тавдугаар сарын башёд 69 дэх Их аварга Хакүхо М.Даваажаргал тус тус тэргүүлсэн бол долдугаар сарын башёд 70 дахь Их аварга Харумафүжи Д.Бямбадорж Эзэн хааны цом хүртсэн юм.



Дархан аваргуудын нэрэмжит тэмцээн болно

Монголын үндэсний бөхийн холбооноос ирэх сард бөхийн өргөөнд болох барилдааны хуваарийг гаргажээ. Энэхүү хуваарийн дагуу арваннэгдүгээр сарын 5-ны 14.00 цагаас Увс нуур дэвжээний намрын нээлтэд зориулсан Дархан аварга Х.Баянмөнхийн нэрэмжит, улс, аймгийн алдар цолтой 224 бөхийн барилдаан болох бол 13-ны 14.00 цагаас Хантайшир дэвжээ үүсэн байгуулагдсаны 15 жилийн ойд зориулсан улс, аймгийн алдар цолтой 224 бөхийн барилдаан болно. Мөн ирэх сарын 20-ны 14.00 цагаас Дархан аварга Б.Түвэндоржийн мэндэлсний 100 жилийн ойд зориулсан улс, аймгийн алдар цолтой 224 бөхийн барилдаан тус тус зохион байгуулагдах юм байна.

СПОРТ



Венгер: Шилдэг хөлбөмбөгчдийг багтаа авч үлдэх үргэлж л хэцүү байдаг

Английн “Арсенал” клуб багийн гол хөдөлгөгч хүч болчихоод байгаа Месут Озил болон Алексис Санчестай гэрээгээ сунгахыг хичээж байгаа ч үр дүнд хүрээгүй л байна. Учир нь тэд өндөр цалин шаардаж байгаа учраас гэрээ сунгах асуудал бага зэрэг удааширч байж магадгүй юм. Тэгвэл энэ талаар “Арсенал”-ын дасгалжуулагч Арсен Венгер өөрийн байр сууриа илэрхийлжээ. Тэрбээр “Шилдэг хөлбөмбөгчид гэрээгээ сунгахдаа мөнгө бус харин багийнхаа тоглолтод зохицох, төвшин нь тохирч буй эсэхийг гол үндсээ болгодог байх. Тэд ядуу хүмүүс биш болохоор багийнхаа ирээдүй, зохицлыг хардаг. Бид урьдын адил

зарчимдаа үнэнч хэвээр байгаа. Өгч чадах хэмжээний цалингаа л өгдөг. Сүүлийн үед арай өөр цалингийн бодлого баримтлах болсон л доо. Шилдэг хөлбөмбөгчдийг багтаа авч үлдэх үргэлж хэцүү байсаар ирсэн. Учир нь тэднийг өөр багууд авахыг хүсдэг. Хөлбөмбөгчид ч гэрээ хийх асуудал дээр нухацтай хандаж, байж болох хамгийн өндөр цалинг авахыг хичээдэг. Учир нь хөлбөмбөгчид дээд төвшинд 10 жил орчим л тоглох чадвартай байдаг. Энэ үедээ өндөр цалин авахыг хүсэх нь аргагүй. Би бүхий л амьдралынхаа туршид хөлбөмбөгчдөдөө аль болох өндөр цалин олгохыг л хүсч, тэмүүлж яваа. Хөлбөмбөгчид дөрвөн жилийн гэрээ үзэглэнэ гэдэг үнэндээ хоёр жилийн л гэрээ байдаг. Учир нь хоёр жилийн дараагаар дахиад гэрээ сунгах зайлшгүй шаардлага гарч ирдэг” хэмээн ярьжээ.

“Реал” Роналдотой гэрээгээ сунгаснаа ирэх долоо хоногт зарлана

Испанийн алдарт “Реал Мадрид” клубын довтлогч Криштиано Роналдо багтайгаа таван жилийн гэрээ байгуулахаар тохиролцсон ажээ. Cadena SER-ийн мэдээлж байгаагаар эдүгээ 31 настай Португал хөлбөмбөгчтэй гэрээгээ сунгасан талаар Мадридын баг ирэх долоо хоногт албан ёсоор зарлах юм байна. Тэрбээр шинэ гэрээ ёсоор жилдээ 23 сая еврогийн цалин авах бололтой. Түүний одоогийн цалин нь 2 саяар их юм. Роналдо одоогоор 2018 оны зургадугаар сар хүртэл “Реал”-тай гэрээтэй байгаа билээ.

“ПСЖ” Икардиг сонирхсон хэвээр...

Италийн “Интер” клубын ахлагч, довтлогч Мауро Икарди багийн хөгжөөн дэмжигчидтэй тун тааруу харилцаатай байгаа. Тиймдээ ч багаасаа явж магадгүй болчихоод байна. Тэгвэл Икардиг Францын “ПСЖ” клуб сонирхсон хэвээрээ байгаа ажээ. Парис хотын баг түүнийг зуны солилцооны цонхоор сонирхож байсан юм. Тэгвэл нэгдүгээр сард солилцооны цонх нээгдэхэд дахин дайралт хийгээд үзэх бололтой. Икардигийн төлөө “Наполи” 60 сая евро төлж магадгүй байгаа юм. Харин Италиас өөр гадны багт зарна гэвэл 110 сая евро төлөх ёстой болох аж. Икарди Сери А лигийн эхний найман тойрогт зургаан гоол оруулж, хоёр гоолын дамжуулалт өгчихөөд байна.

“Лестер”-ийн “Үнсгэлжингийн үлгэр” үргэлжилж, “БАРСЕЛОНА”-ГИЙНХАН ПЕПИЙГ ГОМДООЛОО



Оросын “Ростов”-ын талбайд зочилж, 0:1-ээр буулгаж авсан билээ. Ингэснээр эхний гурван тоглолтод бүгдэд нь хожиж, есөн оноотой боллоо. Мөн бүх өрсөлдөгчөө 1:0-ээр буулгаж авч, хаалгандаа ганц ч гоол алдсангүй. Энэ үзүүлэлтээрээ “Малага” болон “Лестер”-ийн үзүүлсэн рекордтай зэрэгцэж байна. Гэхдээ хамгийн содон нь хөлбөмбөгийн хамгийн төгс үр дүн болох 1:0-ээр бүх өрсөлдөгчөө хожсонд л байгаа юм. Германы “Байерн Мюнхен”-ийг хүртэл тэд талбайдаа 1:0-ээр буулгаж авч дөнгөсөн.

“Арсенал”-ын том хожил, Өзилийн анхны хет-трик

Аваргуудын лигийн гуравдугаар тойргийн хүрээнд хамгийн олон гоолын зөрүүгээр хожсон баг нь “Арсенал” боллоо. “Их буучид” талбайдаа Болгарын “Лудогорец” клубыг хүлээж авч, 6:0-ээр бутниргэсэн юм. Ойрын үед “Арсенал” өрсөлдөгчөө ийм олон гоолын зөрүүгээр хожоогүй. Тэр дундаа Аваргуудын лигт. Мөн “Арсенал” Арсен Венгерийн удирдлага дор Европын тавцанд 100 дахь ялалтаа авч байгаа нь энэ юм. Ингэхдээ Аваргуудын лигт 81 хожил авсан бол урьдчилсан шатны тоглолтод 13, Европын цомд зургаан удаа хожиж байжээ. Тэгвэл “Арсенал”-ын Германы хагас хамгаалагч Месут Өзил энэ тоглолтод гурван гоол оруулж, хет-трик хийсэн билээ. Энэ түүний хөлбөмбөгийн замналдаа хийж байгаа анхны хет-трик юм байна. Тэрбээр тоглолтын дараа хувцас солих өрөөнд багийнхантай хамт гурван гоол оруулсны баяраа тэмдэглэж, зургаа татуулсан аж. Мөн хет-трик хийсэн бөмбөгөө гэртээ авч харьжээ.

Н.ПУНЦАГБОЛД

Европын хамгийн нэр хүндтэй тэмцээн болох Аваргуудын лигийн гуравдугаар тойргийн тоглолтууд өнгөрсөн мягмар, лхагва гарагийн шөнө боллоо. Мягмар гарагийн шөнө болсон хамгийн онцлох тоглолт нь Английн аварга “Лестер” клуб талбайдаа Данийн “Копенгаген”-ийг хүлээж авсан “тулаан” байсан юм. Английн премьер лигтээ тун тааруухан амжилттай яваа “Үнсгэлжингийн үлгэр”-ээ үргэлжлүүлж байна. Тэд гурван тойргийн дараах байдлаар хэсэгтээ гурван хожил авч, есөн оноотой болсон. Тэгвэл нийт найман хэсгийн 32 багаас гурван тойргийн дараах байдлаар есөн оноо авсан ердөө л гурван баг байгаа. “Барселона”, “Атлетико Мадрид”, мөн “Лестер”. Нөгөө хоёр багтайгаа харьцуулжгүй бүрэлдэхүүнтэй, Аваргуудын лигийн ямар ч туршлагагүй баг нь “Лестер”.

...Месси энэ улирал Аваргуудын лигт хоёр тоглолтод оролцоод л зургаан гоол оруулж, мэргэн буучийн жагсаалтыг ганцаараа тэргүүлж байна. Тоглолтын дараа “Барселона”-гийнхэн бүгд л Мессиг магтсан. Дасгалжуулагч Луис Энрике “Би хэзээ ч Мессид эргэлзэж байгаагүй...”

Тэр дундаас дэлхий нийтийн анхаарлыг татсан тоглолт нь “Барселона” талбайдаа “Манчестер Сити”-г хүлээж авсан тоглолт байлаа. Өмнө нь хоёр баг хэсгийн шатанд хэд хэд тулсан. Харин энэ удаад бол Пеп Гвардиоло “Манчестер Сити”-гийн хамтаар “Барселона”-гийн талбайд зочилсон учраас илүү их ач холбогдолтой, анхаарал татсан тоглолт болсон юм. Энэ “тулаан”-д хоёр баг эн тэнцүү өрсөлдөх байх гэж олон хөгжөөн дэмжигч таамаглаж байсан байх. Гэвч “Барса” өрсөлдөгчөө 4:0-ээр шүүрдэж, Мессигийн шоу болоод л өнгөрлөө. Хамгийн гол буруутан нь “Сити”-гийн хаалгач Браво

байлаа. Хаалгаа орхиж гарч ирж тоглох гэж байсан дутуу дамжуулалт өгсөн. Улмаар Суаресын цохисон бөмбөгийг 16-гийн шугамны гаднахааснаас болж улаан хуудас хүртэж, багаа хөөдсөн. Ингээд л хүн дутуу багийг “Барса” бүрэн утгаараа илүүрхэж, Месси хет-трик хийж, Неймар нэгийн нэмснээр 4:0-ээр “шүүрдсэн”. Месси энэ улиралд Аваргуудын лигт хоёр тоглолтод оролцоод л зургаан гоол оруулж, мэргэн буучийн жагсаалтыг ганцаараа тэргүүлж байна. Тоглолтын дараа “Барселона”-гийнхэн бүгд л Мессиг магтсан. Дасгалжуулагч Луис Энрике “Би хэзээ ч Мессид эргэлзэж

байгаагүй. Түүнд эргэлзэж байгаа хүн байвал тэр тэнэг байж таарна” хэмээн хэлсэн. Мөн Суарес твиттер хуудсаараа дамжуулж “Баяр хүргэе Лео. Гайхалтай тоглолт, агуу ялалт байлаа. Бид цаашид ч энэ мэт ялалтыг авах болно” хэмээн жиргэсэн юм.

“Атлетико”-гийн содон амжилт

Аваргуудын лигийн тойрог бүрт л сонирхолтой тоглолт өрнөж, шинэ шинэ амжилтууд гарсаар байгаа билээ. Тэгвэл Испанийн “Атлетико Мадрид” клуб гуравдугаар тойрогт

энэ жил Аваргуудын лигт ч гэсэн тун давгүй амжилттай явна. Тэд дөрөвдүгээр тойрогт “Копенгаген”-ы талбайд зочилж тоглох юм. Мөн “Лестер”-ээс хагас хамгаалагч Махрез гурван тоглолтод гурван гоол оруулчихаад байгаа. Гуравдугаар тойрогт ч гэсэн хожлын гоолыг оруулсан юм.

Пеп шинэ багтайгаа хуучин багийнхаа эсрэг тоглоод бутниргүүлээ

Аваргуудын лигийн хүрээнд лхагва гарагийн шөнө олон сонирхолтой тоглолт болсон.

MMINFO

ТАЛ НУТГИЙН ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ

MMINFO АПП
Тал нутгийн өдөр тутмын мэдээ мэдээлэл таны гарт...

ТАТАХ PLAY STORE | ТАТАХ APP STORE

СПОРТ

ДЭЛХИЙН ШИЛДЭГ ГЭРЭЛ ЗУРАГ

Ц.БАТНАСАГ: Токио-2020 зуны ОЛИМПТИЙН НААДМЫН ЭХНИЙ ЦИКЛД ЗАЛУУ ТАМИРЧДАА СОЙЖ БАЙНА

Н.БАТЗАЯА

Монголын боксын холбооны нарийн бичгийн дарга, ОУХМ Ц.Батнасагтай “Чингис хаан-Улаанбаатарын цом” олон улсын боксын тэмцээний талаар ярилцлаа.



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

“Чингис хаан-Улаанбаатарын цом” олон улсын боксын тэмцээн эхэллээ. Тэмцээний талаархи мэдээлэл өгөхгүй юу?

“Олон улсын сонирхогчдын боксын холбооны буюу АИВА 2016 оны календарчилсан хөтөлбөрт багтсан “Чингис хаан-Улаанбаатарын цом” олон улсын тэмцээн гурав дахь хоногтоо үргэлжилж байна. Энэ удаагийн тэмцээнд зургаан орны нийт 81 тамирчин оролцлоо.

81 тамирчин цомын төлөө өрсөлдөж байна гэлээ. Ямар улсын тамирчид оролцож байна вэ?

“Олон улсын чанартай тэмцээн учраас олон тамирчин оролцлоо. Тухайлбал, ОХУ, БНХАУ, Узбекистан, Сингапур, Унгар, Монголын эрэгтэй 61, эмэгтэй 24 тамирчин оролцож байна.

Энэ тэмцээн анх 1969 онд зохиогдож байсан гэсэн. Тэмцээний түүхийн талаар дурсвал?

Тийм. “Чингис хаан-Улаанбаатарын цом” тэмцээн нь анх 1969 онд зохион байгуулагдаж байсан. “Улаанбаатарын цом” Олон улсын тэмцээнийг “Чингис хаан-Улаанбаатарын цом” нэртэйгээр 16 жилийн дараа

...Манай улсаас олимпийн хүрэл медальт Д.Отгондалай, залуучуудын ДАШТ-ий мөнгөн медальт Б.Түвшинбат, Азийн аварга З.Энхзориг нараас бусад шигшээ багийн тамирчид оролцож байгаа. Энэхүү тэмцээн маань Рио-2016 олимпийн наадмын дараах анхны тэмцээн...

сэргээн зохион байгуулагдаж байгаагаараа онцлогтой. Ер нь 27 жил зохион байгуулагдаж байгаа гэж ойлгож болно.

Манай улсын боксын шигшээ багийнхан бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцож байгаа юу?

Манай улсаас олимпийн

хүрэл медальт Д.Отгондалай, залуучуудын ДАШТ-ий мөнгөн медальт Б.Түвшинбат, Азийн аварга З.Энхзориг нараас бусад шигшээ багийн тамирчид оролцож байгаа. Энэхүү тэмцээн маань Рио-2016 олимпийн наадмын дараах анхны тэмцээн. Бидний хувьд Токио 2020 олимпийн зуны олимпийн наадмын циклийн эхний тэмцээн болж буйгаараа онцлог юм. Тиймээс бид энэ тэмцээнд аль болох залуу тамирчдыг дэмжиж, гаргаж ирэх зорилготой. Ер нь бусад орны тамирчдыг харж байхад ч ихэвчлэн залуу тамирчид оролцож байна.

Нийт хэдэн жинд тамирчид өрсөлдөж байгаа вэ?

Нийт 12 жинд тамирчид өрсөлдөж байна. Тодруулбал, эрэгтэй 49, 52, 56, 60, 64, 69, 75, 81 найман жинд, эмэгтэй 51, 54, 60, 69 дөрвөн жинд өрсөлддөө.

Тэмцээний эхний өдрийн тулааны таалар мэдээлэл өгөхгүй юу?

Эхний өдүүдэд Д.Мөнх-Эрдэнэ 49 кг, О.Мөнхсайхан 56 кг, Э.Цэндбаатар 56 кг, О.Батзориг 69 кг, Узбекистаны боксчин Ф.Мелибоев 69 кг, БНХАУ-ын боксчин Ху Ричабилге 69 кг, Б.Мөнх-Ирээдүй /69 кг/, БНХАУ-ын боксчин Жилей Жан 75 кг-д

эхний ялалтаа авлаа. Харин манай улсын эмэгтэй боксчдоос М.Нандинцэцэг, Л.Алтанцэцэг, Д.Шинэцэцэг, У.Шинэцэцэг, М.Мягмаржаргал нар өрсөлдөгчөө ялж, дараагийн тулаанаа хийх эрхтэй болсон. Мөн Узбекистан боксчин Турсуной Рахимов, Унгарын боксчин Анита Боде нар

ялалт байгуулсан.

Олон улсын тэмцээн учраас шүүгчдийн бүрэлдэхүүн сонирхол татаж байна?

Олон улсын боксын холбоо буюу АИВА-гийн одтой шүүгчид энэхүү тэмцээнийг шүүж байгаа. Тухайлбал, Азийн боксын холбооны тэмцээн зохион

байгуулагч Казахстан улсын иргэн Аслан шүүгчээр ирсэн. Манай улсаас гурван шүүгч ажиллаж байна. Ер нь оролцож байгаа улс болгон өөрсдийн шүүгчтэй ирсэн байна билээ. Тэмцээний маань хагас шигшээ энэ баасан гарагт, шигшээ тоглолт нь бямба гарагт болох юм.

МЭДЭЭЛЭЛ

Шатрын өсвөрийн тамирчид оюун ухаанаа сорьж байна

Шатрын өсвөр үеийн ДАШТ Гүрж улсын Батуми хотод эхэллээ. Гурван насны ангилалд болж буй тус тэмцээнд манай улсаас эх орноо төлөөлж дэлхийн аварга, сурагчдын дэлхийн аваргын мөнгөн медальт, Ази тивийн аварга Д.Мөнхзул, өсвөрийн дэлхийн аваргын мөнгөн медальт, сурагчдын дэлхийн аварга, Ази тивийн



аварга Е.Төгсгөмөр, сурагчдын дэлхийн аваргын мөнгөн медальт, Ази тивийн аварга Г.Амартүвшин тэргүүтэй 18 шатарчин оюунаа сорьж байна. Тус тэмцээн энэ сарын 30-нд өндөрлөнө.

Монгол, Оросын баг халз тулааны спортоор өрсөлдөнө

Орос-Монголын хамтын ажиллагаа-2016” бизнес форумыг 10 дугаар сарын 27-30-нд Новосибирск хотод зохион байгуулна. Орос, Монголын хооронд дипломат харилцаа тогтсоны 95 жилийн ойноор энэ болох бизнес форумаар хоёр улсын эдийн засаг, боловсрол, соёл, спорт, шинжлэх ухаан, эрүүл мэнд, бизнесийн олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, Монголын үндэсний үйлдвэрлэлийг ОХУ-ын зах зээлд гаргах төсөл,

хөтөлбөрүүдийг танилцуулах зэрэг асуудлыг хэлэлцэх юм. Мөн энэ үеэр хоёр улсын урлаг, спортын салбарыг хамруулсан арга хэмжээ нэг нь Монгол, Оросын тамирчдын тулааны урлагийн төрлөөр халз тэмцээн зохион байгуулна.

Халз тулааны урлагт багтах найман спортоор манай тамирчид ОХУ-ын тамирчидтай өрсөлдөхөөр нэрс нь тодорчээ. Харин Оросын тамирчдаас хэн сонгогдож, халз тулаанд өрсөлдөх нь хараахан тодорхой болоогүй байна. Тэмцээн

энэ сарын 27-29-нд болно. Монголын тамирчдаас боксын спортоор Э.Баярхүү /64 кг/, жүдогоор Г.Болдбаатар /60 кг/, чөлөөт бөхөөр Д.Цогтбаатар /61 кг/, байлдааны самбогоор Б.Дамланпүрэв /62 кг/, кикбоксор С.Батжаргал /67 кг/, муатай боксоор Б.Гантогтох /60 кг/, холимог тулаан /ММА/-аар /С.Сүхболд /66 кг/, таэквондогоор П.Бямбадорж /57 кг/, сонгомол бөхөөр Б.Хаш-Эрдэнэ /65 кг/ нарыг тодруулаад байна.

Лаура үл мэдэгдэх Марина нэртэй охиныг фэйсбүүкийнхээ найзаас хассанаас хойш түүний хамгийн сайн найзууд нэг нэгээрээ хэрцгийгээр амиа алдаж эхэлнэ.

Гэртээ харьж явсан залуу цовоо цолгиун нэгэн бүсгүйтэй замдаа танилцаж хадлангийн бригад дээр хамтдаа ирснээр тэдний хувь заяа огт өөр өөр тийш эргэнэ. Гэхдээ амьдрал хэзээ ч тохиолдож болох гэнэтийн үйл явдлуудын өмнө залуус бэлэн байх болов уу?

100,000T
Telenor Card

50,000T
Telenor Card

30,000T
Telenor Card

15,000T
Telenor Card

100,000T
Telenor Card

50,000T
Telenor Card

100,000T
Telenor Card

50,000T
Telenor Card

100,000T
Telenor Card

50,000T
Telenor Card

100,000T
Telenor Card

50,000T
Telenor Card